



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 168

Улаанбаатар хот

Г Гүйцэтгэх захирлын албан тушаалд Г
· томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.3, Компанийн тухай хуулийн 84.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, 34.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 10.1, 10.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Блюскай секьюритиз” ХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд Эрдэнэбагана овогтой Алтаншагайг томилохыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ийг мөрдөж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг чанд биелүүлж ажиллахыг “Блюскай секьюритиз” ХК / Э.Алтаншагай/-д үүрэг болгосугай:

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000311